



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АРХАНГАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ
ШИЛЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНД ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2018 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: УАГ-ГАГ/2019/01-ГА

Цэцэрлэг хот
2019 он

**Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр**

Утас: 7033-3141 Цахим хаяг: Ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер Т.Байгалмаа

Утас: 7033-2860 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

ГАБ-ийн ахлагч, Ахлах аудитор Д.Нэргүйбаатар

Утас: 7033-3019 Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

ГАБ-ийн аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 7033-3019 Цахим хаяг: Tsoq-erdeneg@audit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Аудитын тайланг
бэлтгэсэн:

ҮАГ-ын харъяа
Архангай аймгийн
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх
аудитор

Д.Уламбаяр

Утас: 70332141

Аудитын менежер

Т.Байгалмаа

Утас: 70332860

Ахлах аудитор

Д.Нэргүйбаатар

Утас: 70333019

Аудитор

Г.Цог-эрдэнэ

**Уг тайланг ҮАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү.**

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
дээрх утас, 70332141
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум, 3-р
баг, аймгийн ЗДТГ-ын
байр, А корпус, 3-р
давхар 311 тоот өрөө

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Бүлэг 1. Орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.

1.1. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ нь нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.

1.2. Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

1.3. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй буюу эрх шилжүүлэхдээ хугацаа алдсанаас зарим ТАХ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.

Бүлэг 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.1. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

2.2. Зарим гүйцэтгэгч нар гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

2.3. Захиалагчийн гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт үр муутай сул байгаагаас бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон байна.

2.4. Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргын дотоод хяналт хийгээгүй байна.

Бүлэг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин хангагдаагүй, хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй байна.

3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг төлөвлөөгүй, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

3.3. Өмнөх зөвлөмжийг хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Хавсралтууд



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХОХБТХ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
СТСХ	САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
ИТХТ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
БСШУСС	БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААН СПОРТЫН САЙД
БОАЖС	БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
ЗТХС	ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
ХНХС	ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ТАХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ
ЗГХЭГ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
МСҮТ	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ
ЭМТ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ХАА	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ШӨХТГ	ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР
ТББ	ТЕНДЕРИЙГ БАРИМТ БИЧИГ
ЕБС	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
ОНХС	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
ДЗОУБ	ДЭЛХИЙН ЗӨН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА
ЭМГ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
НТШ	НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ
ЗҮБҮА	ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГА ҮНИЙН АРГА
СХАА	САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ТБОНӨХБАҮХАТХ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ
БХБС	БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын код: УАГ-ГАГ/2018/01-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний Аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилт:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжүүлэн 2018 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, тайланг УАГ-т хүргүүлэх болон орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аймгийн ТЕЗ-д эрх шилжүүлэн 2018 онд улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох байгууллагуудыг хамруулан шалгалаа. Мөн аймгийн төв болон суманд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт, гүйцэтгэлийг түүвэрлэн газар дээр нь үзэж танилцлаа.



Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа, тайлбар авах, шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, давтан тооцоолох, анхан шатны баримтаас хөөн шалгах, бодитоор оршин байгаа эсэхийг үзэх буюу ажиглах, баримтжуулах зэрэг аудитын арга зүйн горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур:

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль
- Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”
- Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”
- Сангийн Сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

**Аудит хийсэн багийн
бүрэлдэхүүн:**

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд



ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Г.Цог-эрдэнэ нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

**Аудитын тайлангийн
бүтэц, түүнд тусгах
мэдээлэл,
хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ .

Аудитын тайланд аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах бүх нотлох зүйл, мэдээллийг хангалттай зохистой хэмжээгээр оруулсан болно.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулан саналыг авч, аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан эцсийн байдлаар ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 2018 онд Архангай аймгийн Засаг даргад Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан 6108.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4458.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Үүнд:

- БСШУССайдаас эрх шилжүүлсэн 10 төсөл арга хэмжээ-3378.0 сая төгрөг
- БОАЖСайдаас эрх шилжүүлсэн 2 арга хэмжээ 140.0 сая төгрөг
- Эрүүл мэндийн сайдаас эрх шилжүүлсэн 1 арга - 60.0 сая төгрөг
- ЗТХСайдаас эрх шилжүүлсэн 1 арга хэмжээ-600.0 сая төгрөг
- ХНХСайдаас эрх шилжүүлсэн 1 арга хэмжээ- 80.0 сая төгрөг
- Сангийн сайдаас эрх шилжүүлсэн 1 арга хэмжээ- 200.0 сая төгрөг

Эрх шилжүүлсэн ТАХ-ний 75.8 хувь нь БСШУССайдын, 13.4 хувь нь ЗТХСайдын багцаас, 4.8 хувь нь Сангийн Сайдын, 3.1 хувь нь БОАЖСайдын багцаас, үлдэх хувь нь ХНХСайд, Эрүүл мэндийн сайдын багцаас санхүүжихээр байв.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу:

1. БСШУССайдын багцаас 3364.8 сая төгрөг
2. БОАЖСайдын багцаас 128.0 сая төгрөг
3. ЭМСайдын багцаас 59.6 сая төгрөг
4. ХНХСайдын багцаас 79.8 сая төгрөг нийт 3632.2 сая төгрөгийн санхүүжилт аймгийн Төрийн сангийн дансаар дамжиж гүйлгээ хийгдсэн байна.

Харин аймгийн Засаг даргад ТЕЗ нараас эрх шилжүүлж гүйцэтгэгчийг орон нутагт сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан нийт 742.0 сая төгрөгийн дараах арга хэмжээнүүдийн санхүүжилт нь аймгийн Төрийн сангаар дамжиж гүйлгээ хийгдээгүй байна. Үүнд:

1. ЗТХСайдаас эрх шилжүүлсэн Тариат сумын Мөрөн баг дахь Дасгалын шороон замын засвар шинэчлэлт 5,7 км-гэрээний дүн 553.0 сая төгрөг
2. Сангийн Сайдаас эрх шилжүүлсэн Цэцэрлэг хотын Шинэ наран хорооллын төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах-гэрээний үнэ 189.0 сая төгрөг

ТЕЗ-аас 2018 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлээгүй дараах төсөл арга хэмжээнүүд хуулиар батлагдсан байв. Үүнд:

- Архангай аймгийн Хөгжимт драмын театрын барилга угсралтын ажил
- Эрдэнэмандал сумын 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Хангай сумын 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга
- Цахир сумын 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга
- Ихтамир сумын төв доторх хатуу хучилттай 1.7 км авто зам
- Өгийнуур 35 км цахилгаан дамжуулах агаарын шугам
- Хүүхэд залуучуудын соёл спортын төв, усан бассейн
- Хангай сумын 75 ортой дотуур байрны барилга
- Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”



Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 16 арга хэмжээнээс он дамжих барилга угсралтын 3 ажлаас бусад 13 нь 2018 онд ашиглалтанд бүрэн орохоор төлөвлөгдсөн боловч тэдгээрийн 1 нь эрх шилжүүлэх хугацаа оройтсон, 3 нь гүйцэтгэгчээс шалтгаалан хугацаандаа ашиглалтанд ороогүй он дамжин хэрэгжихээр болсон байна.

Харин эрх шилжүүлээгүй хөрөнгө оруулалтын нийт 9 арга хэмжээнээс дараах арга хэмжээнүүд 2018 онд огт хэрэгжээгүй байна. Үүнд:

Он дамжин хэрэгжиж буй ажлууд:

1. Тариат сумын “Сумын төвийн шинэчлэл”
2. Хангай сумын 75 ортой дотуур байр
3. Хүүхэд залуучуудын соёл спортын төв, усан бассейны барилга

Шинээр хэрэгжих:

4. Хангай сумын 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга

Архангай аймагт ТЕЗ нараас эрх шилжүүлсэн 2018 онд бүрэн ашиглалт орсон байх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт 69.2 хувь, эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын хувьд хэрэгжилт 55.6 хувьтай байна.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТАГТ ЭРХ ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ХИЙГДСЭН БАЙНА.

Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээ нь нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөгдсөн байна.

График 1.



Төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймгийн Засаг даргад 2018 онд 6108.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4458.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 16 төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Үүнийг эрх шилжүүлсэн ТЕЗ ба хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төрлөөр ангилж график (1)-аар харуулбал:

Архангай аймагт 2014-2018 онд улсын төсвөөс хэрэгжүүлсэн ТАХ-ийг төрлөөр нь ангилж график (2)-аар харуулбал:

График 2.




График 2-оос Улсын төсвийн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын тухайд барилга байгууламж барих ажил жил бүр 2-4, тоног төхөөрөмж худалдан авах жил бүр 1-2 арга хэмжээ буюу тогтмол хэмжээтэй, харин их засварын ажил 3-13 хүртэл хэлбэлзсэн нь их засвар жил бүр харилцан адилгүй хийгдэж байгааг харуулж байна. Мөн 2018 оноос зураг төсөв боловсруулах ажлын эрхийг орон нутагт шилжүүлж эхэлсэн байна.

1.1. Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрийг орон нутгийн урт болон дунд хугацааны хөтөлбөрийн бодлогын баримт бичгүүдтэй тулган шалгахад Эрдэнэбулган сумын 2-р сургуульд авсан шалгалтын материал



засах программ, тоног төхөөрөмжөөс бусад арга хэмжээ нь Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн аль нэгэнд тусгагдсан буюу нийцэж байна.

- 1.2. 2018 онд эрх шилжүүлсэн шинээр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргаас Ерөнхий сайд болон ТЕЗ нарт гаргаж хүргүүлсэн хөрөнгө оруулалтын саналд тусгагдаагүй байна.

Аймгийн Засаг даргаас 2017 оны 08 сарын 01-ний өдрийн 01/884 тоот албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын дарга, УИХ-ын гишүүд, Яамдууд 2018 онд улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг жагсаалтаар гаргаж хүргүүлсэн байна. Уг жагсаалтанд Цэцэрлэг сумын соёлын төвийн барилгыг шинээр барих санал тусгагдсан бөгөөд Хашаат, Өлзийт сумын соёл төвийн барилгыг шинээр барих санал тусгагдаагүй байна.

Хууль, журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

- 1.3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтанд нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхойгүй төсөл арга хэмжээ тусгаж батлуулаагүй байна.

Эрх шилжүүлсэн ТАХ-ээс 2018 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, авто зам барих, Эрдэнэмандал сумын сургууль, цэцэрлэгийн уурын зуухны засвараас бусад 14 ТАХ-үүд нь хуульд ерөнхий нэрээр тусгагдсан байна. Тухайлбал: Төсвийн тухай хуулийн XVIII.2.1-д “Эрүүл мэндийн салбарын их засвар улсын хэмжээнд”, X.1.2.1-д Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын их засвар /улсын хэмжээнд/, XIII.4.1-д “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /улсын хэмжээнд/” гэж тус тус заажээ. БОАЖСайдаас эрх шилжүүлсэн “Агаарын бохирдол бууруулах, тоног төхөөрөмж худалдан авах”, “Эрдэнэмандал сумын хогийн цэгийг хашаажуулах” арга хэмжээнүүд Төсвийн тухай хуульд тодорхой нэрээр тусгагдаагүй, эрх шилжүүлсэн тушаалд хуулийн кодыг бичиж ирүүлээгүй байлаа.

Эрх шилжүүлсэн ТАХ-ний ТЕЗ-ийн тушаалаар баталсан нэр, байршлыг орон нутагт өөрчилж хэрэгжүүлсэн зөрчил илрээгүй болно. /Дэлгэрэнгүй хавсралт №1-ээс үзнэ үү/

- 1.4. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төсвийг жагсаалт батлуулахаас өмнө боловсруулж баталгаажуулсан байна.

Тухайлбал: Хашаат, Өлзийт, Цэцэрлэг сумын соёлын төвийн барилгуудын зураг, төсвийг “Криетив Монголиа” ХХК-иар хийлгүүлсэн байна.

- 1.5. Шинээр хэрэгжүүлэх 3 сумын соёлын төвийн барилгын газрын зөвшөөрлийг харьяалах сумын Засаг дарга нарын захирамжаар, техникийн нөхцлийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулсан байна.
- 1.6. Архангай аймагт ТЕЗ-аас эрх шилжүүлэн 2018 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний зураг, төсөвт өөрчлөлт ороогүй. Энэ талаар аймгийн ГХБХБГ-аас албан бичгээр тайлбар судалгааг гаргаж ирүүлсэн.



- 1.7. Их засвар, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан хэрэгжүүлсэн байна.
- 1.8. Эрх шилжүүлсэн ТАХ-нд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

- 2.1. *ТАХ-ний хэрэгжүүлэх эрхийг орон нутагт шилжүүлэхдээ хугацаа алдсанаас тендер шалгаруулалт оройтож, төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.*

БОАЖСайдаас 100.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй “Архангай аймгийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ” хэрэгжүүлэх эрхийг 2018 оны 10 сарын 01-ний А371 тушаалаар шийдвэрлэсэн байна. Ингэж оны сүүлийн хагаст эрх шилжүүлж хугацаа алдсанаас **гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагаа он дамжиж улмаар тендер амжилтгүй болсон байна. Түүнчлэн одоог хүртэл гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулаагүй 2018 онд эрх шилжүүлсэн арга хэмжээ хэрэгжээгүй байна.**

Ер нь орон нутагт эрх шилжүүлэх ажлыг оны сүүлийн хагаст шийдвэрлэх нь тендер шалгаруулах хугацаа алдаж, ондоо багтахгүй болох, улмаар тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулах, хөрөнгө оруулалтын ажил нь хүйтний улирал эхэлснээр тухайн онд хэрэгжих боломжгүй болж он дамжин хэрэгжих нөхцөл үүсэж, улмаар хийгдээгүй ажилд санхүүжилт олгох, зориулалтын бус зарцуулах зэрэг эрсдэлд хүргэж болзошгүй байна.

Иймд орон нутагт эрх шилжүүлж байгаа ТАХ-ний асуудлыг оны эхний хагаст шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байгааг ҮАГ-аар уламжлуулан холбогдох ТЕЗ нарт хүргүүлж байна.

Эрх шилжүүлсэн, тендер шалгаруулалт зохион байгуулсан хугацааны талаар дэлгэрэнгүйг Хавсралт №2-оос үзнэ үү.

- 2.2. Төсвийн ерөнхийлөн захирагч үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан байна.

Эрх шилжүүлсэн 16 төсөл арга хэмжээнээс 1 ТАХ-г хуулийн дагуу гүйцэтгэгчийг шууд сонгон худалдан авах гэрээ байгуулсан ба 14 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар томилсон байна. Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ОНӨГ-ын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтнүүдийг томилсон ба ХАА-ны мэргэшсэн эрх бүхий иргэний төлөөллийг үнэлгээний хорооны гишүүнээр томилж ажиллуулсан байна.



2.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч захиалагчаар баталгаажуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны урилгыг нийтлэхээс өмнө ТАХ бүрийн тендерийн баримт бичгийг боловсруулсан байх боловч түүнийг захиалагчаар батлуулаагүй байна. Энэ нь Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.2¹-д заасныг зөрчсөн байна.

2.4. Гүйцэтгэгчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан боловч зарим сонгон шалгаруулалтанд оролцогчид холбогдох байгууллагуудад гомдол гаргаж шийдвэрлүүлсэн байна.

Тухайлбал: Цэцэрлэг сумын Соёлын төвийн 250 суудалтай барилгын ажлын тендер шалгаруулалтыг 2018 оны 05 сарын 30-нд урилгыг нийтэлж эхлүүлсэн боловч уг тендерт өрсөлдөөнийг хязгаарласан тухай гомдлыг "Өндөр Хайрхан дулаан" ХХК-аас ШӨХТГ-т гаргасныг тус газар шалгаад үндэслэлтэй болохыг тогтоосон байна. ШӨХТГ-ын шийдвэрийн дагуу ТББ-т өөрчлөлт оруулан тендер шалгаруулалтыг зохион байгуулснаар хугацаа алдаж шалгарсан гүйцэтгэгчид 2018.10.19-нд гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.5. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнасан байна.

Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 14 ТАХ-ний гүйцэтгэгчийг аймгийн ОНӨГ-т зохион байгуулж дараах 2 ТАХ-ний ХАА-г бусад байгууллага зохион байгуулжээ. Үүнд:

- Хайрхан сумын ЕБС-ийн дотуур байрны их засварын ажил нь нийт 209.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үүний 50.0 сая төгрөгийг БСШУССайдын багцаас, 70.0 сая төгрөгийг Хайрхан сумын ОНХС-аас, үлдэх 89.3 сая төгрөгийг ДЗОУБ-аас санхүүжүүлэхээр батлагдсан тул санхүүжилтийн ихэнх хувийг гаргаж байгаа ДЗОУБ уг тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.
- ЭМСайдаас Төвшрүүлэх сумын ЭМТ-ийн халаалтын тогооны засварын ажил гүйцэтгүүлэх эрхийг аймгийн ЭМГ-т шилжүүлсэн бөгөөд цахим системд ОНӨГ-аар зохион байгуулах эрх үүсээгүй тул тендер шалгаруулалтыг аймгийн ЭМГ-т зохион байгуулсан байна.

Дээрх бүх тендерийн урилгыг www.tender.gov.mn цахим сайт болон өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин” зэрэг сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн ба 100 хувь цахимаар зохион байгуулсан байна.

Аймгийн ОНӨГазрын зохион байгуулсан ХАА-ны дүнд нийт 567.5 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон боловч Сангийн Сайдын 2016 оны 415 тушаалаар баталсан

¹ Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд тараана.




журмын 4.26²-д заасны дагуу Сангийн яамнаас санхүүжилт олгодог тул дээрх тендерийн хэмнэлтийг орон нутагт зарцуулах боломжгүй байна.

Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний 37 хувийг Нээлттэй тендер шалгаруулалтын, 44 хувийг харьцуулалтын, 13 хувийг Зөвлөх сонгох бага үнийн, 6 хувийг шууд гэрээ байгуулах аргыг сонгон зохион байгуулжээ.

Сүүлийн 4 жилийн ХАА-ны журмын сонголтыг харьцуулсан графикаар харуулбал:

График 3.



Дээрх график 3-аас харахад сүүлийн жилүүдэд HTШ арга буурч, харьцуулалтын арга, шууд гэрээ байгуулах, Зөвлөх үйлчилгээний арга ашиглах хувь өссөн байна. Энэ нь ТЕЗ нараас эрх шилжүүлсэн ТАХ-ний төсвийн хэмжээтэй шууд холбоотой өөрөөр хэлбэл хуульд заасан HTШ-ын арга хэрэглэх хэмжээний төсөвт өртөгтэй ажлуудыг ТЕЗ нараас шилжүүлээгүйтэй холбоотой байна.

Зарим гүйцэтгэгч нар гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээгүй байна.

2.6. Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 16 арга хэмжээнээс он дамжих барилга угсралтын 3 ажлаас бусад 13 нь 2018 онд ашиглалтанд бүрэн орохоор төлөвлөгдсөн боловч тэдгээрийн 1 нь эрх шилжүүлэх хугацаа оройтсон, 3 нь гүйцэтгэгчээс шалтгаалан хугацаандаа ашиглалтанд ороогүй он дамжин хэрэгжихээр болсон байна. Үүнд:

Гэрээний үүргээ хугацаанд хэрэгжүүлээгүй гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

Төсөл арга хэмжээний нэр	ТЕЗ	Гүйцэтгэгч ийн нэр	Гэрээний үнэ /сая.төг/	Гэрээний эцсийн хугацаа	Хугацаа хэтэрсэн хоног /2019.04.01/

² Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан, эрх шилжүүлж, аймаг, нийслэл, сум, дүүрэг худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын хувьд тухайн ТЕЗ-ийн хөрөнгө, оруулалт, их засварын дансаар дамжиж санхүүжилт хийгдэнэ. ТЕЗ орон нутгаас ирүүлсэн санхүүжилтийн материалыг ажлын 3 хоногт хянаж Сангийн яаманд хүргүүлнэ.



“Цэцэрлэг хотын шинэ наран хорооллын төлөвлөгөө зураг төсөв боловсруулах”	Сангийн Сайд	Хатанбаа тар ХХК	189.0	2018.11.20	130
Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолбор, Цогчэн дуганыг сэргээн завсарлах зураг төсөв боловсруулах”	БСШУСайд	Сүлд Проект ХХК	171.0	2018.12.15	105
Эрдэнэмандал сумын хогийн цэгийг хашаажуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх”	БОАЖСайд	Тамир Таун ХХК	40.0	2018.10.27	154

2.7. Захиалагч, зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Архангай аймгийн МСҮТ-ийн халаалтын тогооны засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэсэн “БГБС” ХХК-ий ажлын гүйцэтгэлээс бусад ТАХ-ний зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн баримттай байна. Гэвч улсын комисс хүлээн авсан баримтанд зохиогчийн ба захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг хавсаргаагүй байгаа нь Барилгын тухай хуулийн 48.7.1³-д заасныг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна.

2.8. Гүйцэтгэгч төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн төрийн сан дахь дансаар эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт ТАХ-нд зориулан ТЕЗ нараас нийт 3632.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт №3-аас үзнэ үү)

ТЕЗ нараас орон нутагт шилжүүлсэн санхүүжилт, аймгийн төрийн сангаас хийсэн зарлагын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2.

ТЕЗ	Эрх шилжүүлсэн санхүүжилтийн дүн	ТЕЗ-ын багцаас хийгдсэн санхүүжилтийн дүн	Үүнээс:		
			Гүйцэтгэгчид олгосон	Зураг төсөв, зохиогч, захиалагчийн хяналтын байгууллагад олгосон	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан
БСШУСС	3378.0	3364.8	2508.0	19.8	837.0
БОАЖС	140.0	128.0	28.0		100.0
ЗТХС	600.0	0	0	0	0

³ Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтанд оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана. 48.5.3. зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ЭМС	60.0	59.6	58.6		1.0
ХНХС	80.0	79.8	79.2		0.6
Сангийн Сайд	200.0	0	0	0	0
Нийт дүн	4458.0	3632.2	2673.8	19.8	938.6

МСҮТ-ийн халаалтын тогооны засварын ажлын гүйцэтгэгч “БГБС” ХХК нь зохиогчийн хяналт хийсэн нотлох баримтгүйгээр хяналтын зардлыг зарцуулсан байх тул 306.2 мянга төгрөгийг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудын гүйцэтгэгч нарыг орон нутагт сонгон шалгаруулж 752.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч ЗТХСайд, Сангийн сайд нар дээрх ТАХ-үүдийн санхүүжилтийг аймгийн Төрийн сангийн дансаар дамжуулалгүй гүйцэтгэгч нарт олгосон байна. Энэ нь ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг орхигдуулж, гэрээний биелэлтийг тооцох боломжгүй болгосон байна.

Захиалагчийн гэрээний хэрэгжилтэнд тавих хяналт үр дүн муутай, сул байгаагаас бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон байна.

2.8. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэнд захиалагчийн тавих үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлж байгаа боловч үр дүн муу байна.

Захиалагчийн хяналтыг үе шат бүрт хэрэгжүүлж ил, далд ажлын актыг хянаж ажлын гүйцэтгэлийн санхүүжилтыг олгох маягыг хянаж баталгаажуулсан байна. Гэвч ТАХ бүрийн гүйцэтгэлийн санхүүжилт олгох баримтанд захиалагчийн хяналтын тэмдэглэл, гүйцэтгэгчид өгсөн үүргийн биелэлтийн тэмдэглэл зэргийг хавсаргаагүй байгаа нь Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.9⁴-д заасныг зөрчсөн байна.

Түүнчлэн захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа хяналтын инженерүүд нь барилга, байгууламж, их завсарын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналт тавьж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах үүргээ хэрэгжүүлээгүйгээс гүйцэтгэгч нарт бодит гүйцэтгэсэн ажлаас илүү санхүүжилт олгосон зөрчил илрээд байна. Энэ талаар доорх 2.9-ээс дэлгэрэнгүй танилцана уу.

2.9. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүйгээс нийт 793.9 сая төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Тухайлбал:

1. Хашаат сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилга /нийт гэрээний үнэ 1280.0 сая төгрөг, 2018 онд санхүүжих 1.0 тэрбум төгрөг/-ын ажлыг гүйцэтгэгч “Хатуу төмөр” ХХК нь 2018 онд зөвхөн 1-р давхарын угсралт, өрлөгийн ажлыг хийж дуусгасан бөгөөд тухайн жилийн батлагдсан

⁴ ... Хяналтын инженер ... нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгсөн үүргийн даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргах бөгөөд барилга ашиглалтанд орсоны дараа санхүүжилтийн матеарилын хамт захиалагчийн архивт хадгалуулна.



санхүүжилт 1.0 тэрбум төгрөгийг бүрэн авах зорилгоор нийт ажлын **78.1** хувийг гүйцэтгэсэн гэж “**хуурамч гүйцэтгэл**” гаргаж ирүүлсэн байна.

Зураг 1.Хашаат сумын Соёлын төвийн барилгын ажил 2019.03.31



Энэхүү илүү санхүүжилт авах зорилгоор “Хатуу төмөр” ХХК-ний огт хийгдээгүй ажлууд болох **2-р давхарын угсралт, дээвэр, хаалга цонх, дотор гадна заслын ажил, шалны ажил** зэргийг хийсэн гэж бодит гүйцэтгэлээс хэт их зөрүүтэй гаргасан “**хуурамч гүйцэтгэл**”-ийг захиалагчийн хяналтын инженер нь холбогдох журамд заасан эрх үүргийг хэрэгжүүлэхгүйгээр тухайн жилийн батлагдсан санхүүжилт 1.0 тэрбум төгрөгийг бүрэн олгуулахаар баталгаажуулсан байна. Түүнчлэн аймгийн ГХБХБГ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүд энэхүү “**хуурамч гүйцэтгэл**” бүхий санхүүжилт хүссэн материалыг бодит гүйцэтгэлтэй харьцуулан шалгахгүйгээр “Хатуу төмөр” ХХК-д 991.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 2018 онд бодит хийсэн ажлын гүйцэтгэлд тохирох санхүүжилтээс урьдчилсан тооцоогоор 535.5 сая төгрөгөөр илүү байна.

- Цэцэрлэг сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилга /гэрээний үнэ 1335.0 сая төгрөг, 2018 онд санхүүжих 1.0 тэрбум төгрөг/-ын ажлын гүйцэтгэгч “Алтайн бумбат өргөө” ХХК-ний ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд зөвхөн суурийн нүх ухсан, аяган суурийг цутгаж бэлтгэсэн байна. Гэтэл гүйцэтгэгч байгууллагаас суурийн ажил **100 хувь**, угсралтын ажлын **82 хувийг** гүйцэтгэсэн гэж бодит байдал дээр хийгдээгүй ажлыг хийсэн мэтээр “**хуурамч гүйцэтгэл**” гаргасныг захиалагчийн хяналтын инженер бодит гүйцэтгэлд тохирох санхүүжилтээс хэт их буюу 260.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталгаажуулсан ба аймгийн ГХБХБГ,



(Зураг 2. Цэцэрлэг сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэл 2019.03.30)



ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүд дээрх материалыг бодит гүйцэтгэлтэй харьцуулан шалгахгүйгээр “Алтайн бумбат өргөө” ХХК-д 2018 онд **260.0** сая төгрөгийн санхүүжилт олгосон нь бодит хийсэн ажлын гүйцэтгэлд тохирох санхүүжилтээс урьдчилсан тооцоогоор 124.5 сая төгрөгөөр илүү байна.

3. Өлзийт сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилга /гэрээний үнэ 1380.5 сая төгрөг, 2018 онд санхүүжих 850.0 сая төгрөг/-ын ажлын гүйцэтгэгч “Билэгт багана” ХХК-ний ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд 2018 онд дээврийн ажил **100 хувь**, хаалга цонхны ажил **100 хувь**, гадна заслын ажил **97.9 хувь**, дотор гэрэлтүүлэг хүчит төхөөрөмж суурилуулах ажил **39.2 хувь** гүйцэтгэсэн гэж санхүүжилт авсан нь бодит байдал дээр хийгдээгүй байна.

Зураг 3. Өлзийт сумын Соёлын төвийн барилга 2019.03.31



Дээрх ажлуудыг хийсэн мэтээр “хуурамч гүйцэтгэл” гаргасныг захиалагчийн хяналтын инженер нь бодит гүйцэтгэлд тохирох санхүүжилтээс илүү буюу тухайн



жилийн батлагдсан санхүүжилт 850.0 сая төгрөгийг олгохоор баталгаажуулсан ба аймгийн ГХБХБГ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн дарга, холбогдох мэргэжилтнүүд дээрх материалыг бодит гүйцэтгэлтэй харьцуулан шалгахгүйгээр “Билэгт багана” ХХК-д 2018 онд **841.9** сая төгрөгийн санхүүжилт олгосон нь бодит хийсэн ажлын гүйцэтгэлд тохирох санхүүжилтээс урьдчилсан тооцоогоор **133.9** сая төгрөгөөр илүү байна. “Билэгт багана” ХХК-ний ирүүлсэн тайлбараас үзэхэд гадна заслын ажлыг зураг төсөвт ердийн тоосго, шавардлага, эмульсээр хийхээр тусгасан байсныг зураг төсвийн байгууллага, ашиглагчийн саналаар өнгөлгөөний тоосгоор хийхээр өөрчлөн гүйцэтгэсэн бөгөөд одоогоор 87.2 сая төгрөгөөр өнгөлгөөний тоосго авч нөөцөлсөн гэсэн байна. Үүнээс үзвэл анх баталсан төсөв нэмэгдэж дараа жилд төсвөөс нэмж хөрөнгө шаардаж болзошгүй байна.

Дээрх асуудал нь Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.3, 5.2⁵, 5.3⁶, 5.4⁷-д заасан үүргийг захиалагчийн хяналтын инженер, СТСХ, ХОХБТХ, ГХБХБГ-ын дарга мэргэжилтнүүд хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна. Иймд дээрх зөрчлийг гаргасан албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэх, бусдад давуу байдал олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ашиглуулсан байж болзошгүй үйлдлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах эсэх талаар зөвлөгөө авахаар ҮАГ-т хүргүүлээд байна.

2.10. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.3-д заасны дагуу эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын тайланг хугацаанд гаргаж хүргүүлсэн байна. Тухайлбал: 2018 онд эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг 2018.12.10-ны 02/2092 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2.11. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нарт хариуцлага тооцоогүй байна.

ТЕЗ-аас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн хариуцлага тооцсон байдлыг шалгасан дүнгийн нэгтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 3.

⁵ Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

⁶ Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол ... шалгалт хийж зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.

⁷ Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Нийт эрх шилжсэн ТАХ	Гэрээ байгуулсан	2018 онд ашиглалтанд орох	Хугацаандаа хүлээлгэн өгсөн	Гэрээ дүгнэсэн	Хугацаандаа хүлээлгэн өгөөгүй	Хариуцлага тооцсон
16	15	12	9	9	3	0

/Дэлгэрэнгүйг Судалгаа №3 болон Хавсралт №4-өөс үзнэ үү/

Гэрээний үүргээ хугацаандаа хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарын гэрээт хугацаанаас хоцорсон хоногийн талаарх мэдээллийг тайлангийн 2.8-д Хүснэгт 1-ээр харуулсан болно. Дээрх гүйцэтгэгч нарт гэрээнд заасан хариуцлагыг ногдуулаагүй байгаа нь захиалагч гэрээний үүргийг хангуулах талаар арга хэмжээ авахгүй байгааг харуулж байна. Иймд дараах гүйцэтгэгч нарт ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний дагуу гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоногт ногдох алдангийг тооцож үлдэгдэл санхүүжилтээс суутгах албан шаардлагыг захиалагчийг төлөөлж гэрээ байгуулсан аймгийн ГХБХБГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

Хүснэгт 4.

Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч ийн нэр	Гэрээний үнэ /сая.төг/	Үлдэгдэл санхүүжи лт /сая.төг/	Гэрээний эцсийн хугацаа	Хугацаа хэтэрсэн хоног /2019.04.01/
“Цэцэрлэг хотын шинэ наран хорооллын төлөвлөгөө зураг төсөв боловсруулах”	Хатанбаа тар ХХК	189.0	**	2018.11.20	130
Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолбор, Цогчэн дуганыг сэргээн завсарлах зураг төсөв боловсруулах”	Сүлд Проект ХХК	171.0	84.1	2018.12.15	105
Эрдэнэмандал сумын хогийн хашаажуулах, төног төхөөрөмж нийлүүлэх”	Тамир Таун ХХК	40.0	12.0	2018.10.27	154

** аймгийн Төрийн сангийн дансаар санхүүжилт дамжаагүй учир санхүүжилтийн үлдэгдлийг хэмжээг тогтоогоогүй.

Хөрөнгө оруулалтын үйл явц, хэрэгжилт, үр дүнд аймгийн Засаг даргын дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

2.12. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба, ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтсээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт, зарцуулалтанд хяналт шалгалт хийдэггүй байна.

Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын 2019.04.01-ны өдрийн 08/402 тоот албан бичиг, аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2019.03.22-ны өдрийн 48 тоот албан бичиг/

Иймээс СХАА болон СТСХ-ээс ТАХ-ны гүйцэтгэл санхүүжилтэнд хяналт шалгалт хийлгэж, шалгалтын дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээ авч байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИН ХАНГАГДААГҮЙ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДИТ ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.

3.1. 2018 онд ашиглалтанд орсон төсөл арга хэмжээ бүрэн ашиглагдаагүй байна.

Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, ашиглалтын байдлыг нэгтгэж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5.

Нийт ТАХ-ний төрөл	Үүнээс:		2018 онд улсын комисс хүлээн авсан	Хэрэгжилт ийн хувь	Хүлээн авсан ТАХ-ээс ашиглагдаж байгаа	Ашиглалтын хувь
	Он дамжин хэрэгжих	2018 онд ашиглалтанд орох				
Барилга	3					
Авто зам		1	1	100	1	100
Их засвар		7	7	100	6	85.7
Тоног төхөөрөмж		3	1	33.3	1	100
Зураг төсөв		2	0	0		
Нийт дүн	3	13	9	69.2	8	88.9

Дэлгэрэнгүйг Судалгаа 3-аас үзнэ үү.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцоогүй байна.

3.2. Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

Орон нутагт эрх шилжүүлж хэрэгжүүлэн 2018 онд байнгын ашиглалтанд хүлээн авсан 9 ТАХ-ээс Эрдэнэмандал сумын ЕБС, цэцэрлэгийн халаалтын шугамаас бусад ТАХ-үүд бүрэн ашиглагдаж байгаа бөгөөд МСҮТ-ийн халаалтын тогооны их засвар ашиглалтын явцад чанарын доголдол гарсан, ажлыг дутуу гүйцэтгэсэн талаар ашиглагчаас гомдол тайлбар ирүүлсэн байна.

Иймд ашиглагчийн гомдлыг барагдуулах дутуу ажлыг гүйцээх, гэмтлийг завсарлуулах арга хэмжээг гүйцэтгэгч нараар хийлгүүлэх тухай хугацаатай албан шаардлагыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн ГХБХБГ-т хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2018 онд байнгын ашиглалтанд хүлээн авсан ТАХ-ээс нийт 275.4 сая төгрөгийн дараах ажлуудыг ашиглагчийн нягтлан бодох бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна. Үүнд:

- Цэнхэр сумын ЕБС-ийн хичээлийн байрны их засвар 76.7 сая төгрөг



- Эрдэнэмандал сумын сургууль, цэцэрлэгийн уур зуухны засвар 148.7 сая төгрөг
- Хайрхан сумын сургуулийн дотуур байрны засвар 50.0 сая төгрөг

Энэ нь Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.1⁸-д заасныг зөрчсөн байна.

Иймд ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэлээ.

Хөрөнгө оруулалтын зарим ТАХ-ний бодит үр өгөөж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Барилга хот байгуулалтын сайдын багцаас 2014 оноос хойш он дамжин хэрэгжүүлж буй Тариат сумын “**Сумын төвийн шинэчлэл**”-ийн ажлын нийт санхүүжилтийг 93 хувь буюу 4459.2 сая төгрөгийг гүйцэтгэгч авсан бөгөөд 2016 онд ашиглалтанд өгөх ёстой боловч гэрээний хугацаа 3 жил хэтэрсэн байхад хүлээлгэн өгөөгүй байна. Гүйцэтгэгч “Эх голомтын илч” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй буруутай үйл ажиллагааны улмаас ашиглалтанд орох хугацаа хойшилсоор байна. Иймд дээрх төсөл арга хэмжээг яаралтай ашиглалтанд оруулах талаар мэргэжлийн байгууллагууд холбогдох арга хэмжээ авч ажиллах саналыг ҮАГ-аар уламжлуулан Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлж байна.

Ингэснээр орон нутагт улсын төсвийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжих ТАХ-ний үр дүн, үр ашгийг иргэд шуурхай хүртэж, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөсөн үр өгөөж хангагдах юм.

Энэ ТАХ-ний тухайд 2015 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хийгдээгүй ажилд 1308.5 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан зөрчил илэрснийг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрөөгүй тул хөндлөнгийн мэргэжлийн шинжээч ажиллуулж бодит гүйцэтгэл, санхүүжилтийг гаргуулж холбогдох арга хэмжээ авахуулах саналыг аймгийн Аудитын газраас тайлангаар ҮАГ-т уламжилж байсан болно.

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж үрэлгэн зарцуулаагүй.

Орон нутагт эрх шилжүүлэн 2018 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийн тухайд төсөвт өртгийг нэмэгдүүлж зарцуулсан зөрчил илрээгүй.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Аймгийн Аудитын газраас өмнөх онд хэрэгжүүлсэн аудитын дүнгээс 2 албан шаардлагыг аймгийн ГХБХБГ, ОНӨГ-т хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Харин аймгийн Засаг даргад хүргүүлсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан тухай

⁸ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана. Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, завсарын төрлөөр тодруулга тайланд тусгана.



хариу ирүүлсэн боловч бодит байдал дээр ашиглалтанд хүлээн авсан ТАХ бүрийг бүрэн, төлөвлөгдсөн хүчин чадлаар ашиглаж эхлээгүй, ашиглалтын байдалд дотоод хяналт шалгалт хийгээгүй байгаа нь “Улсын комиссын актаар байнгын ашиглалтанд хүлээн авсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ашиглалтын байдалд аймгийн Засаг даргын дотоод хяналт шалгалтыг жил бүр хийж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тухайн ТАХ-ний төлөвлөгдсөн хүчин чадлыг бүрэн ашиглах, олон нийтийн хүртэх үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн тайлан, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлж байх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гэж үзэхэд хүргэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6⁹-д заасны дагуу өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

-----oOo-----

⁹ Аудитаар илэрсэн зөрчил түүнийг арилгуулахаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй”



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Урт болон дунд хугацааны төлөвлөгөөг үндэслэн ТАХ-г төлөвлөсөн боловч эрх шилжүүлэх хугацаа алдсанаас зарим ТАХ он дамжин хэрэгжихэд хүрсэн байна.
2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.:
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
4. Захиалагчийн төсөл арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтэнд тавих хяналт үр дүн муу байгаагаас бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон байна.
5. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байна.
6. Төсөл арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтэнд Аймгийн Засаг даргын дотоод аудитын алба, СТСХ-ээс дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг ашиглаж эхлээгүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг төлөвлөж бодит үр нөлөөг тооцоогүй байна.
8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын явцд нийт 1288.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх таслан зогсооход чиглэсэн 1181.4 сая төгрөгийн 4 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага, хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг аймгийн ТЕЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх 2 саналыг ҮАГ-т уламжиллаа.

-----oO-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

Аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд

1. Улсын төсвөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцах тул энэ талаар тодорхой арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангуулах
2. Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, чанар, хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтанд аудитын тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргуулан авч үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ харгалзан үзэх

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга П.Энхтайванд

1. Ашиглагч байгууллагаас тухайн ТАХ-г зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай эсэх хүсэлтийг албан бичгээр авч баримтжуулан түүнд үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлж байх
2. Хөрөнгө оруулалтын ТАХ бүрийн бодит үр өгөөжийг тооцож байх, жил бүрийн хөрөнгө оруулалтын талаарх аймгийн хэмжээний нэгдсэн судалгаа боловсруулж, дүн шинжилгээ хийн аймгийн Засаг дарга болон бодлогын түвшинд холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр хангаж байх

ОНӨГ-ын дарга Х.Ганхуягт

1. Тендерийн баримт бичгийг боловсруулахад өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэх алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллах

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Ж.Мөнхбатад

1. Гүйцэтгэлийг баталгаажуулсан баримтанд захиалагчийн хяналтын тэмдэглэл, үүргийн биелэлтийн тэмдэглэлийг хавсаргаагүй бол санхүүжилт олгохгүй байх арга хэмжээг авч хэвшүүлэх
2. Тухайн ТАХ-ний санхүүжилтийг олгохоос өмнө ядаж 1 удаа гүйцэтгэл бодиттой эсэхийг хянах арга хэмжээг авч санхүүжилтийг олгох эсэхийг шийдвэрлэж байх

Уламжлах санал:

Аудитын явцад ажиглагдсан зүйл, аудитын дүнд үндэслэн дараах асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр ҮАГ-т уламжилж байна.

Үүнд:



1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний эрхийг орон нутагт шилжүүлэхдээ тухайн оны эхний хагаст шийдвэрлэж байх саналыг ТЕЗ нарт уламжилж өгнө үү.

Ингэснээр ТАХ-ний хэрэгжилт удаашрах, он дамжин хийгдэх, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгох, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах зэрэг эрсдлийг бууруулах боломжтой юм.

2. Барилга хот байгуулалтын сайдаас эрх шилжүүлэн 2014 оноос хойш он дамжин хэрэгжиж буй Архангай аймгийн Тариат суманд хэрэгжиж буй **“Сумын төвийн шинэчлэл”**-ийн ажлыг гүйцэтгэгч “Эх голомтын илч” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй буруутай үйл ажиллагааны улмаас ашиглалтанд орох хугацаа хойшилсоор байна. Иймд дээрх төсөл арга хэмжээг яаралтай ашиглалтанд оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах саналыг Барилга хот байгуулалтын яаманд уламжилж өгнө үү.

Үүний үр дүнд хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөсөн үр өгөөж хангагдах улмаар аудит хийсний үр өгөөж, үр нөлөө олон нийтэд тодорхой болно.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцаж санал ирүүлсэн ба тайлангийн төсөлд өгөх саналгүй гэсэн болно.

*А/а Наринболорын
Т.Мөнхл. Энх*

**АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
85139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг.
Утас/Факс: (976) 7333 3231.
И-мэйл: arkhangai.gov@gmail.com.
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2019.04.17 № 03/509

тантай *2019.04.15-ний № 298* -т

**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаа.

2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын тайлбар болон саналыг тус газарт албан бичгээр хүргүүлсэн.

Тайлангийн төсөлд саналгүй болно.

ДАРГА
Б.ЦЭРЭННАДМИД

658130460



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/09

Цэвэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1 дэх заалт, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 онд эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын гүйцэтгэлийн аудитын газарт цаасаар болон цахимаар мөн аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нэргүйбаатар/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБЯАР

651190029

D:\2019\АЛБАН БИЧИГ\2019 tushaal.doc



Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэрүүлэх Аудиторын 2019 оны 4-р сарын едрийн тушаалын Хавсралт № 01

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын нэр: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Аудитын код: УАГ-ГАГ/2019/01-ГА

№	Аудитаар илэрсэн Зөрчлийн агуулга	Зөрчлийн дүн /сая тегерг/		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Өгсөн зөвлөмжийн тоо		Үр өгөөж	
		Тоо	Дүн /сая тегерг/	Тоо	Дүн /сая тегерг/	Тоо	Дүн /сая тегерг/	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж ашиглалтанд хүлээн авсан төсөл арга хэмжээг ашиглагчийн бүртгэл тайланд тусгуулаагүй Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх заалт, Сангийн Сайдын 2016 оны 415 тушаалаар баталсан журмын 6.1 дэх заалтуудыг зөрчсөн.	1	275.4	1	275.4					1	275.4
2	Захиалагчийн хяналт хангалтгүйгээс зураг төсөвт тусгасан ажлыг дутуу хэрэгжүүлсэн, гэрээний үүргээ хугацаандаа хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нэрт гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүй ТБОНХБХАУХАТХ-ийн 46.1.6, 49.2.10 дахь заалтуудыг зөрчсөн.		112.1	1	112.1					1	112.1
3	Зураг төсөвт тусгасан ажлыг дутуу гүйцэтгэсэн, ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй, гэмтэл, эвдрэл гарсан, гүйцэтгэгч нэрт санхүүжилт олгосон баримтанд захиалагчийн хяналтын тэмдэглэл, үүргийн биелэлтийн тэмдэглэлийг хавсаргаагүй байгаа нь Сангийн Сайдын 2016 оны 415-р тушаалаар баталсан журмын 4.9-д заасныг зөрчсөн байна.										
4	Захиалагч Сангийн Сайдын 2016 оны 415-р тушаалаар баталсан журмын 4.3, 5.2-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй улмаар 4.1.1-д "Захиалагч барилга байгууламж, их завсарын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ ... ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргана." гэж заасныг зөрчиж бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт гүйцэтгэгч нэрт олгосон		793.9	1	793.9					1	793.9



5	МСУТ-ийн халаалтын тогооны засварын ажил гүйцэтгэсэн "БГБС" ХХК-д зохиогчийн хяналтыг хэрэгжүүлснийг нотлох анхан шатны баримтгүйгээр нийт 0.3 сая төгрөгийг олгосон, захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийг гүйцэтгэгч нарт олгосон байгаа нь Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын 4, 18-д заасныг зөрчсөн байна.	0.3			1	0.3		1	0.3
6	БОАЖЯ-аас орчны бохирдлыг хэмжих багаж тоног төхөөрөмж худалдан авах, бохирдлыг бууруулах дэвшилтэт технологи бүхий хөтөлбөр хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийн эрхийг 2018 оны 10 сарын 01-ний өдрийн тушаалаар шилжүүлсэн, ЭБ сумын 2-р сургуульд шалгалтын материал засах програм авах эрхийг 2018.11.07 өдөр шилжүүлсэн байна. БОАЖЯ-аас эрх шилжүүлэх хугацаа оройтноос төндөрийг 2018.12.23-нд нээсэн. Үүний улмаас тухайн ТАХ он дамжин хэрэгжижээ хүрсэн байна.	107.0					1		
7	Төндөрийн баримт бичгийг хуулийн хугацаанд боловсруулсан боловч захиалагчаар батлуулаагүй байгаа нь Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалын хавсралтаар баталсан журмын 3.2-д "Уналгээ хороо төндөрийн баримт бичгийн төслийг боловсруулан захиалагчаар батлуулж, баталгаажсан хувийг төндөр шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдэд төрөөн" гэж заасныг зөрчсөн байна.							1	
Нийт дүн		1288.70		1181.40	1.00	0.30		3	1181.70
								4	



Хавсралтууд:

Хавсралт №1

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Архангай аймагт 2018 онд эрх шилжүүлсэн

№	ТӨЗ	Төсөл арга хэмжээний нэр	Хуулийн код	Төсөвт өртөг	2018 онд санхүүжих дүн /сая.төг/	Ангилал
1	ЭМС	Архангай Төрөх эмнэлэгийн засвар / Архангай Эрдэнэбулган сум/	XVIII.2.1.2.1	60.0	60.0	Их засвар
ЭМС-н дүн				60.0	60.0	
2	БСШУСС	Сургуулийн засвар /Архангай Цэнхэр сум /	XIII.4.1.1	80.0	80.0	Их засвар
3	БСШУСС	Соёлын төвийн барилга 250 суудал /Архангай Хашаат сум/	XIII.2.1.25	1,500.0	1,000.0	Барилга угсралт
4	БСШУСС	Соёлын төвийн барилга 250 суудал /Архангай Өлзийт сум/	XIII.2.1.24	1,500.0	850.0	Барилга угсралт
5	БСШУСС	Соёлын төвийн барилга 250 суудал /Архангай Цэцэрлэг сум/	XIII.2.1.23	1,500.0	1,000.0	Барилга угсралт
6	БСШУСС	Сургууль цэцэрлэгийн уурын зуухны засвар /Архангай Эрдэнэмандал/	XIII.1.2.26	150.0	150.0	Их засвар
7	БСШУСС	Сургуулийн дотуур байрны засвар /Архангай Хайрхан/	XIII.4.1.2	50.0	50.0	Их засвар
8	БСШУСС	Спорт заалны засвар/Архангай Өндөр-Улаан сум/	XIII.1.1.1.7	37.0	37.0	Их засвар
9	БСШУСС	Цэцэрлэгийн засвар /Архангай Өндөр-Улаан сум/	XIII.1.1.1.8	33.0	33.0	Их засвар
10	БСШУСС	Төв Монголын байгаль, түүх соёлын цогцолбор,Цогчин дуганыг сэргээн засварлах зураг төсөл боловсруулах	XIII.2.1.1.1	171.0	171.0	Зураг төсөв
11	БСШУСС	Архангай аймгийн 2-р сургуульд тоног төхөөрөмж худалдан авах /Шалгалтын тоног төхөөрөмж/	XIII.5.1.26	7.0	7.0	Тоног төхөөрөмж
БСШУСС-ын дүн				5,028.0	3,378.0	
12	БОАЖС	Архангай аймгийн Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ, тоног төхөөрөмж		100	100	Тоног төхөөрөмж
13	БОАЖС	Орон нутагт хогийн цэгийг устгах, хашаажуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх /Архангай Эрдэнэмандал/		40	40	Тоног төхөөрөмж
БОАЖС-ын дүн				140.0	140.0	
14	ЗТХС	Дасгалын шороон замын засвар шинэчлэлт 5.7 км /Архангай Тариат сум/	XIV.1.2.5	600.0	600.0	Авто зам
ЗТХС-ын дүн				600.0	600.0	
15	ХНХС	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн халаалтын зуухны шинэчлэл засвар/ Архангай Цэцэрлэг/	X.1.2.1.16	80.0	80.0	Их засвар
ХНХС-ын дүн				80.0	80.0	
16	Сангийн Сайд	Цэцэрлэг хотын Шинэ наран хорооллын төлөвлөгөө,зураг төсөв боловсруулах	VIII.1.4.1.26	200.0	200.0	
Сангийн Сайдын дүн				200.0	200.0	
БҮГД				6,108.00	4,458.00	



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Хавсралт №2

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас Архангай аймагт 2018 онд эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, хугацааны судалгаа

Д/д	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	ХАА-нд мөрдөгдсөн журам				ХАА-ны хэлбэр		Тендерт зарцуулсан хугацаа			Зарцуулсан нийт хугацаа (хоног)	
			Нэвтрэлт	Хягаар-лалт	Харцуулалт	Шалгаруулалтын онцгой журам	Цаас	Цахим	Огноо	Дугаар	Тендерийн урилга нийтэлсэн огноо		Гэрээ байгуулах эрх олгосон огноо
А	2	3	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
1	XIII.1.2.26	Сургууль цацарлагын уурин зууны их засвар /Архангай, Эрдэнэмандал сум/ Цэцэрлэг сум/	1					1	2018.05.18	A/239	2018.05.29	2018.07.26	68
2	XIII.2.1.23	Соёлын төвийн барилга /Архангай, Цэцэрлэг сум/	1					1	2018.05.18	A/241	2018.05.30	2018.10.19	85
3	XIII.2.1.24	Соёлын төвийн барилга /Архангай, Влэйнт сум/	1					1	2018.05.18	A/236	2018.05.29	2018.07.30	73
4	XIII.2.1.25	Соёлын төвийн барилга /Архангай, Хашаат сум/	1					1	2018.05.18	A/240	2018.05.30	2018.07.30	73
5	XIV.1.2.5	Диспачин шороон замын засвар, шинэчлэлт 5.7 км /Архангай, Тариат сум/	1					1	2018.03.26	A/117	2018.04.04	2018.06.11	77
6	XIII.4.1.1	Сургуулийн засвар /Архангай, Цэцэр сум/			1			1	2018.06.04	A/279	2018.06.04	2018.07.03	30
7	VIII.1.4.1.26	Цэцэрлэг хотын Шинэ наран хорооллын төлөвлөгөө, зураг төсөв боловсруулах	1					1	2018.06.28	A/318	2018.07.10	2018.09.17	81
8	XIII.4.1.2	Сургуулийн дотуур байрны засвар /Архангай, Хайрхан/			1		1		2018.06.15		2018.06.19	2018.07.27	72
9	X.1.2.1.15	Амгийн МСҮТ-ийн хяналтын төгсгөлийн шинэчлэлт, засвар			1			1	2018.07.16	A/343	2018.08.01	2018.08.28	74
10		Эрдэнэмандал суманд хотийн цаг устгах, хашаажуулах, тонгос төлсөрмөж нийлүүлэх			1			1	2018.06.26	A/304	2018.06.27	2018.09.04	70



11	XIII.2.1.1.1	Төв Монголын байгаль, түүх соёлын центрээр, Цогчин дугаарыг сэргээх засварлах зурга төсөл боловсруулах	1							1	2018.07.10	A/341	2018.07.10	2018.08.17	68
12	XIII.1.1.1.7	Спорт заалны засвар /Архангай, Өндөр- Улаан сум/		1						1	2018.07.30	A/390	2018.09.04	2018.09.14	45
13	XIII.1.1.1.8	Цэцэрлэгийн засвар /Архангай, Өндөр- Улаан сум/		1						1	2018.07.30	A/390	2018.08.03	2018.08.28	30
14		Архангай аймагт Агаарын Бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх	1							1	2018.10.23	A/555	2018.11.23		
15	XVIII.2.1.2.1	Төвсрүүлэх сумын ЭМТ-ийн халаалтын төгрөм засвар	8	0	7	1				1	2018.04.23	ЭМТ/290	2018.06.26	2018.07.23	90



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдал

№	Төсвийн ерөнхийлөн зохиогчийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2018 онд санхүүжүүлсэн дүн	Гүйцэтгэлийн нэр	Гэрээний дүн	Аймгийн Төрийн сангаас 2018 онд олгосон санхүүжилт					
			Эхлэх	Дуусах					9	10	11	12	13	14
A	1	Цэнхэр сумын ЕБС-ийн хөгжлийн байрны их засвар	2018	2018	80,000.0	80,000.0	Гэгээн хяр ХХК	76,726.9	72,720.7					960.9
2	БШШСЯ	Хашаат сумын Соёлын төв	2018	2019	1,500,000.0	1,000,000.0	Халуу тэмэр ХХК	1,279,999.9	1,000,000.0		3045.3			8569.5
3	БШШСЯ	Өлзийт сумын Соёлын төв	2018	2019	1,500,000.0	800,000.0	Билэвт байсан ХХК	1,380,511.6	850,000.0	833,701.2				8149.4
4	БШШСЯ	Цадрал сумын Соёлын төв	2018	2019	1,500,000.0	1,000,000.0	Алтан бумбат өргөө ХХК	1,335,260.4	260,000.0					731495.8
5	БШШСЯ	Эрдэнэбулган сумуудын цагдаагийн уурын зууны засвар	2018	2018	150,000.0	150,000.0	Босал ХХК	145,706.9	148,706.9	146,168.2				2538.7
6	БШШСЯ	Хөвсгөл сумын сургуулийн дотуур байрны их засвар	2018	2018	50,000.0	50,000.0	Гуравтанр ХХК	50,000.0	50,000.0					
7	БШШСЯ	Өндөр-уулан сумын спорт засны засвар	2018	2018	36,891.7	36,891.70	Хяк үзүүр ХХК	36,891.7	36,891.8	36,288.4				602.4
8	БШШСЯ	Өндөр-уулан хүүхдийн чигдрэлийн хөгжлийн засвар	2018	2018	33,000.0	33,000.00	Зогал ХХК	32,997.4	32,997.4	32,424.4				573
9	БШШСЯ	Төв-Мүнхэн байрны туурь соёл хөгжлийн засвар	2018	2018	171,001.0	171,001.0	Бунд прорект хяк	171,000.9	171,000.0					84124.5
10	БШШСЯ	Эрдэнэбулган 2-р сургууль шалгалтын харму засах програмын	2018	2018	7,000.0	7,000.0	Фенероулун ХХК	7,000.0	7,000.0					
		БШШСЯ-ийн дүн			5,027,892.7	3,377,692.7		4,519,085.7	3,394,818.8	2,508,040.4		3,045.3	16,719.9	837,014.2
11	Боловсрол	Архангай аймаг Агаарын болзолтой бүтээгдэхүүн арга хэмжээ	2018	2018	100,000	100,000	Төсөл үндэстэй болсон		100,000					100,000

